



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 715

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4, дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, засаж сэлбэн ашиглах боломжгүй, 14 нэрийн, нийт 39,193,939.00 (гучин есөн сая нэг зуун ерэн гурван мянга есөн зуун гучин ес) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал М.Бямбасүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 13 -ны өдрийн
205... дугаар тогтоолын хавсралт

УРГАМАЛ ХАМГААЛАЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ
ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Факс аппарат panasonic	12/21/2015	ш	1	300,900.00	300,900.00
2	A Colous программ	12/31/2015	ш	1	770,000.00	770,000.00
3	Трактор МТЗ-82	1/1/1986	ш	1	4,522,500.00	4,522,500.00
4	Борнуур цахилгаан үүсгүүр	7/1/2006	ш	1	16,642,969.00	16,642,969.00
5	Дуу хураагуур	5/1/2014	ш	1	275,000.00	275,000.00
6	Чийг температур хэмжилгч	11/25/2015	ш	1	20,000.00	20,000.00
7	Лабораторийн сандал физик	7/7/2006	ш	2	68,000.00	136,000.00
8	Принтер ерson TX-129	12/31/2016	ш	1	390,000.00	390,000.00
9	Ламинатор бокс микр	8/31/2016	ш	1	9,950,000.00	9,950,000.00
10	Хатаах шүүгээ 155	6/1/2014	ш	1	2,500,000.00	2,500,000.00
11	Суурин компьютер	12/29/2017	ш	1	2,200,000.00	2,200,000.00
12	Суурин компьютер	12/31/2016	ш	1	1,329,820.00	1,329,820.00
13	Гэрэл унтраалга	1/1/2014	ш	1	136,950.00	136,950.00
14	Универсал таймар	1/1/2014	ш	1	19,800.00	19,800.00
Нийт дүн					39,125,939.00	39,193,939.00 (гучин есөн сая нэг зуун ерэн гурван мянга есөн зуун гучин ес)